

Ulaanbaatar Chamber of Commerce-Улаанбаатар хотын худалдааны танхим

OtlcStorhbrumemhropocnsloai o20rre,h dhS2020 ·

ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛЬ, ШҮҮГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ НЬ ТАНЫ БИЗНЕСТ ХЭРХЭН НӨЛӨӨЛӨХ ВЭ?

Улаанбаатар хотын худалдааны танхимаас зохион байгуулсан хэлэлцүүлэгт УИХ-ын гишүүн Б.Энхбаяр, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлого зохицуулалтын газрын ахлах шинжээч Ш.Цолмон, УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны мэргэжилтнүүд, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн дэд профессор, доктор О.Мөнхсайхан, Монголын Хуульчдын холбооны гишүүн хуульч өмгөөлөгч С.Халиун, УБХТ-ын Ерөнхийлөгч Ч.Ганхуяг, УБХТ-ын Гүйцэтгэх захирал Б.Хаш-Эрдэнэ болон танхимын гишүүд, хууль зүйн фирмийн хуульчид оролцлоо.

Хэлэлцүүлгийн үеэр дараах саналууд гарав. Үүнд:

- Бизнесийн маргааныг шударга шийдэхэд шүүх, шүүгчийн хараат бус байдлаас гадна мэргэжлийн ур чадвар, эдийн засаг, хөрөнгө оруулалтын талаарх мэдлэг дутмаг байгаа нь ихээхэн нөлөөлж байна.

Нэг хэрэг дээр шүүхийн шат болгонд өөр өөр шийдвэр гарч байгаа нь шүүгчдийн ур чадвар, ёс зүйтэй шууд холбоотой. Тиймээс шүүгчдийн ур чадварт анхаарч, давтан сургалтуудыг зохион байгуулж байхаас гадна орчин үеийн эдийн засаг, бизнесийн харилцаатай холбоотой мэдлэг олгох сургалтуудыг зохион байгуулж байх хэрэгтэй. Тухайлбал шүүгч нар санхүүгийн анхан шатны мэдлэггүй байгаагаас шалтгаалж компанийн үйл ажиллагааны явцад үүссэн энгийн маргаан, дампуурлын хэрэг гэх мэтийг буруу шийдэх, хугацаа алдах байдал их тохиолдож байгаа тул санхүү, хөрөнгө оруулалт гэх мэт тодорхой чиглэлүүдээр сургалтад хамруулж мэдлэгтэй болгох.

Өндөр үнийн дүнтэй, гаднын хөрөнгө оруулалттай хэрэгт үүсдэг нэг том асуудал нь гэрээний орчуулга байдаг. Орчуулгыг нь төгс сайн хийж чадаагүйгээс хэрэг удааширдаг. Гаднын хөрөнгө оруулалттай компани нэмэгдэж, түүнийг дагасан гэрээ хэлэлцээрээс үүдэлтэй маргаан олширч байгаа үед энэ асуудлыг онцгой анхаарах ёстой.

- Шүүх, шүүхийн хараат бус байдлыг сайжруулахын тулд шүүгчид нөлөөлсөн эсэх талаарх гомдлыг хэлэлцэн шийдвэрлэх процессын үед УИХ-ын гишүүний бүрэн эрх үйлчилдэггүй байх, авилгын тухай хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулж авилга өгсөн этгээдийг шийтгэдгийг болиулах, Ерөнхий шүүгч, Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн эрх мэдлийг хязгаарлах, шүүгчэд хүлээлгэх сахилгын болон бусад хариуцлагыг илүү өндөр болгох зэрэг болон саналууд оролцогчдоос гарлаа.

Улаанбаатар хотын Худалдааны танхим тус хэлэлцүүлэгт оролцогчдоос гарсан санал, шүүмжийг нэгтгэн Шүүхийн тухай хууль, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулинд оруулах нэмэлт, өөрчлөлтөд өгөх бизнес эрхлэгчдийн саналыг УИХ-ын Хууль зүйн байнгын хороонд илгээх болно.